



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/108

Алтрага

Мал угаалгын ажил зохион явуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/254 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын А/26 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны шимэгчтэх өвчинтэй тэмцэх арга хэмжээг эрчимжүүлж, нийт мал сүргийг угаалга, туулгалт, боловсруулалтад бүрэн хамруулж, малын хашаа, хороо, өвөлжөө бууцыг халдваргүйтгэх, мал сүргийг гадна шимэгчтэх өвчнөөс эрүүлжүүлж түүхий эд бүтээгдэхүүний чанарыг сайржуулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Хариуцлагатай малчин-Эрүүл мал” улсын аяны хүрээнд Орон нутагт мал угаалгын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэхийг “Чанартай сүрэг” ХХК-ийн захирал (Л.Дүүжий), “Агар Мөрөн ЭНТ” хоршооны дарга (Б.Тунгалагтуул)-нарт даалгасугай.

2. Мал угаалгын ажлыг удирдан зохион байгуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг тархварзүйч (Д.Энхтайван)-д хариуцуулсугай.

3. Мал угаалгын ажилд шаардагдах бензин шатахууны зардлыг шийдвэрлэж, туслалцаа үзүүлж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Дэлгэрмаа), нягтлан бодогч (Э.Ариунаа)-нарт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Даваажав)-д түр хариуцуулсугай.

ДАРГА  Г.ОДСЭР